



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар A/359

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн байгууллагын магадлан
итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.2.13, 2.2.21, 2.2.30 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын "Магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" 2021 оны А/634 дүгээр тушаалыг хүчинчүй болсонд тооцсугай.

САЙД C.ЧИНЗОРИГ

10 Эрүүл мэндийн сайдын 2023 оны
дугаар сарын 10-ны өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж,
үйлчилгээний газрын дарга

Орлогч дарга:

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын
газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын Эрүүл мэндийн
байгууллагын тусгай зөвшөөрөл, магадлан
итгэмжлэлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Зөвлөлийн үндсэн гишүүд:

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын дарга

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын
Тусlamж, үйлчилгээний чанар төлбөрийн
хяналтын газрын дарга

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж,
үйлчилгээний газрын Анхан шатны тусlamж
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн
байгууллагын нэгдсэн холбооны төлөөлөл

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн
тuslamж үйлчилгээний чанарын салбар
зөвлөлийн төлөөлөл

Зөвлөлийн байнгын бус гишүүд:

Хэлэлцэж буй эрүүл мэндийн байгууллагын
тuslamж үйлчилгээний төрөл, чиглэлээс
хамаарч мэргэжлийн салбар зөвлөл,
нийгэмлэгээс төлөөлөл оролцуулна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
10 дугаар сарын 10 -ны өдрийн 10 дугаар
тушаалтын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх орон тооны бус зөвлөл (цаашид "зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Зөвлөл нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3. Зөвлөл нь эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчилүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эрх тэгш байдал, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, шуурхай байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчилгүй байх зарчмыг баримтлан ажиллана.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь дарга, орлогч дарга, үндсэн болон байнгын бус гишүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвлөлийн хурлын бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн магадлан итгэмжлэлд хамрагдах байгууллагын тусlamж, үйлчилгээний чиглэл, төрлөөс хамаарч 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тооцож байнгын бус гишүүдийг тухайн үед нэмэлтээр томилон оролцуулна.

2.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралд саналын эрхгүйгээр оролцно.

2.4. Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх Эрүүл мэндийн хөгжлийн төвд ажлын албатай байна.

2.5. Зөвлөлийн ажиллах хэлбэр нь хурал байх ба танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулна.

2.6. Зөвлөлийн шийдвэр нь тэмдэглэл хэлбэрээр гарах бөгөөд магадлан итгэмжлэл олгох, цуцлах, түдгэлзүүлэх, сэргээх шийдвэр нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажина.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг

3.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.1.2. Эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн магадлан итгэмжлэлийн шинжээчийн дүгнэлт, саналтай танилцаж, магадлан итгэмжлэл олгох, түдгэлзэх шийдвэр гаргах, хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн зарим үйл ажиллагаа (зөвлөн туслах

үйлчилгээ, эмнэлгийн туссламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын сургалт)-г төрийн хэвшилд шилжүүлэх шийдвэр гаргах;

3.1.4. Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад бүхэлд нь ба хэсэгчилсэн үнэлгээг дахин хийлгэх, шинжээчдийн багийг томилох асуудлаар шийдвэр гаргах;

3.1.5. Шаардлагатай тохиолдолд ажлын алба, мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран газар дээр нь ажиллах, хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцох;

3.1.6. Ажлын албаны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;

3.1.7. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийг хэлэлцэх, үүрэг даалгавар, зөвлөмж өгөх;

3.1.8. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Зөвлөлд хандсан өргөдөл, гомдол, маргааныг хянан шийдвэрлэх.

Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг

4.1. Зөвлөлийн дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

4.1.1. Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хурлын дэг, бүрэлдэхүүнийг баталж, хурлын тэмдэглэл, хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулах;

4.1.2. Хурлыг зарлан хуралдуулах, хурлыг удирдах;

4.1.3. Орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, ажлын албанд үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;

4.1.4. Хуралд оролцохдоо ашиг сонирхлын мэдүүлгийн хуудсыг бөглөх.

4.2. Зөвлөлийн орлогч дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

4.2.1. Зөвлөлийн даргын эзгүйд 4.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;

4.2.2. Зөвлөлийн даргаас шилжүүлсэн бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;

4.2.3. Өөрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагын асуудлыг хэлэлцэх тохиолдолд ил зарлан, шийдвэр гаргах, санал хураахад оролцохоос сайн дураар татгалзаж, урьдчилан мэдэгдэх;

4.2.4. Хуралд оролцохдоо ашиг сонирхлын мэдүүлгийн хуудсыг бөглөх;

4.2.5. Хурлын дэг, журмыг баримтлан ажиллах.

4.3. Зөвлөлийн Нарийн бичгийн дарга нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

4.3.1. Нарийн бичгийн дарга нь хурлын төлөвлөгөөг боловсруулан зөвлөлийн даргаар батлуулах, хурлын бэлтгэл ажлыг хангах;

4.3.2. Хурлаар хэлэлцүүлэх асуудлын танилцуулгыг хянаж, хурал болохоос 2-оос доошгүй өдрийн өмнө цахим болон цаасан хэлбэрээр зөвлөлийн гишүүдэд хүргүүлэх;

4.3.3. Тухайн хуралд хүндэтгэх шалтгааны улмаас оролцох боломжгүй гишүүний саналыг бичгээр урьдчилан авах;

4.3.4. Хурлын тэмдэглэлийг хянан зөвлөлийн даргаар баталгаажуулж, шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.3.5. Зөвлөлийн гишүүдийг холбогдох мэдээллээр хангах, зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг хэрэгжүүлэхэд байгууллага, албан тушаалттай хамтран ажиллах;

4.3.6. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой албан хэргийг хөтөлж, баримт бичгийг холбогдох журмын дагуу архивлах;

4.3.7. Зөвлөлийн даргаас өгсөн бусад үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх;

4.3.8. Хурлын дэг, журмыг баримтлан ажиллах.

4.4. Зөвлөлийн гишүүн нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

4.4.1. Зөвлөлийн үндсэн болон байнгын бус гишүүн нь хуралд биечлэн болон цахимаар оролцох;

4.4.2. Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд өөр албан тушаалтнаар орлуулахгүй;

4.4.3. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд зөвлөлийн даргад урьдчилан мэдэгдэх ба хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр ирүүлэх;

4.4.4. Хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, саналаа бэлтгэж оролцох;

4.4.5. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой нэмэлт мэдээлэл авах, хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд асуулт асуух, санал хэлэх, дүгнэлт гаргахад оролцох;

4.4.6. Хурлаас гарсан шийдвэр, зөвлөлийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

4.4.7. Өөрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагын асуудлыг хэлэлцэх тохиолдолд ил зарлан, шийдвэр гаргах, санал хураахад оролцохос сайн дураар татгалзаж, урьдчилан мэдэгдэх;

4.4.8. Хуралд оролцохдоо ашиг сонирхлын мэдүүлгийн хуудсыг бөглөх;

4.4.9. Магадлан итгэмжлэлийн хурлаар хэлэлцүүлсэн байгууллагатай холбоотой мэдээллийн нууцыг хадгалах;

4.4.10. Хурлын дэг, журмыг баримтлан ажиллах.

Тав. Зөвлөлийн хурлын үйл ажиллагаа

5.1. Зөвлөлийн гишүүдийн ирц 70-аас дээш хувьд хүрсэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөрт тооцно.

5.2. Гишүүн нь зөвхөн зөвлөлийн даргын шийдвэрээр хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд цахимаар оролцож болно.

5.3. Цахимаар оролцох гишүүн нь мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, техникийн бүрэн нөхцөлийг хангасан байна.

5.4. Хурлаар хэлэлцэх асуудлыг нээлттэй хэлэлцэж, гишүүдийн ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

5.5. Гишүүний цахимаар болон бичгээр ирүүлсэн саналыг санал хураалтад оруулж тооцно.

5.6. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

5.7.Хурлын шийдвэр нь зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

5.8.Хурлаар хэлэлцэх асуудалд тодруулга авах зорилгоор холбогдох шинжээчдийн багийн гишүүд, албан тушаалтныг хуралд оролцуулж болно.

5.9.Ажлын алба нь хурлын явцыг аудио болон видео бичлэг хэлбэрээр хадгалах ба хуралд оролцогсод, хэлэлцсэн асуудал, асуулт хариулт, санал, шийдвэр зэргийг хураангуйлсан хурлын тэмдэглэлийг хөтөлж, нарийн бичгийн даргаар хянуулж, Зөвлөлийн даргаар баталгаажуулна.

---ООО---